



# МОНГОЛЫН ХӨЛ БӨМБӨГИЙН ХОЛБОО

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар хороо, Хөл бөмбөгийн төв  
Улаанбаатар-210646 Ш/хайрцаг-259  
Утас: (976-11) 345964, 345968, Факс: (976-11) 345966  
Вэб сайт: [www.the-mff.mn](http://www.the-mff.mn)

Улаанбаатар хот  
05 оны 02 сарын 10 өдөр  
№ 03

## МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ САХИЛГЫН ХОРООНЫ ШИЙДВЭР

### Гомдол шийдвэрлэсэн тухай

Монголын Хөлбөмбөгийн Холбоо /МХБХ/-ны Сахилгын хороо Тэмцээн зохион байгуулах хэлтсээс МХБХ-ны Мастер ангиллын Футзалын аварга шалгаруулах тэмцээний явцад 45+ насны ангиллын Дархан хөлбөмбөгийн клубт холбогдуулан Сахилгын хороонд гаргасан хүсэлтийг хүлээн авч хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ нь:**

Гомдлын агуулга: МХБХ-ны “Мастер ангиллын футзалын аварга шалгаруулах тэмцээнд” Дархан клубын 45+насны баг нь багийн мэдүүлгээ ирүүлэн амжилттай бүртгүүлж, сугалааны үйл ажиллагаанд оролцсон болно.

Тэмцээн амжилттай эхлэн явагдах үед Дархан хөлбөмбөгийн клуб эхний тогтолцондоо Хан-Уул V-94 багтай таарч тоглох хуваарьтай байсан ч ирээгүй тул эсрэг багт техникийн хожил олгов. Мөн дараа дараагийн тогтолтууддаа ирээгүй болно.

Гомдлын шаардлага: “дээрх зөрчлийг МХБХ-ны Сахилгын дүрмийн зохих заалтын дагуу шийдвэрлэж өгнө үү” гэсэн байна.

Сахилгын хороо нь хүсэлт гаргагч Тэмцээн зохион байгуулах хэлтсийн хүсэлт болон хавсралтаар ирүүлсэн “Дархан” клубын 45+ насны Мастер ангиллын футзалын аварга шалгаруулах тэмцээнд оролцох мэдүүлэг, тус тэмцээний тогтолтын хуваарь, тогтолтын протокол зэргийг баримтаар судлав.

### ҮНДЭСЛЭХ нь:

- Дархан клуб нь МХБХ-ны Мастер ангиллын футзалын аварга шалгаруулах тэмцээний 45+ насны ангилалд оролцохоор мэдүүлгээ өгч, сугалаанд оролцсон хэдий ч хуваарь тогтолтууддаа оролцохгүй болсон нь МХБХ-ны Тэмцээн зохион байгуулах хэлтсийн ирүүлсэн хүсэлт, багийн мэдүүлэг, тус тогтолтын протокол, тоголтын хуваарь зэргээр тогтоогдож байна.

Энэхүү үйлдэл нь: МХБХ-ны Сахилгын дүрмийн 41 дүгээр зүйлд заасан “Тэмцээнээс гарах” гэдгийн 41.2 дахь хэсэгт “Аливаа клуб, баг тэмцээний сугалаанд оролцсон атлаа тэмцээнд оролцоогүй орхин явсан тохиолдолд үүнийг зөрчил гэж үзнэ” гэж заасны дагуу Сахилгын зөрчил болно.

Иймд Дархан клубын 45+ насны багт МХБХ-ны Сахилгын дүрмийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж үзлээ.

МХБХ-ны Сахилгын дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.2.2, 9 дугаар зүйлийн 9.4 дэх хэсгийг удирдлага болгон **ТОГТООХ нь:**

1. Дархан клубт МХБХ-ны Сахилгын дүрмийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтад заасныг үндэслэн **600,000₮ /зургаан зуун мянган/ төгрөгийн тогтуул нөгдүүлсугай.**
2. Торгуулийн 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор төлөхийг Дархан клубын 45+ насны багт үүрэг болгосугай. Хэрэв төлөөгүй тохиолдолд МХБХ-ны тэмцээн, тогтолтонд оролцуулахгүй.
3. Дээрх шийдвэрт хяналт тавин ажиллахыг МХБХ-ны Тэмцээн зохион байгуулах хэлтэс /ТЗБХ/ болон Санхүүгийн хэлтэс /Т.Энхтүвшин/ нар танилцуулж, шийдвэрийн биелэлтийг ханган ажиллахыг үүрэг болгосугай.
4. Энэхүү шийдвэр гарсан цагаасаа хүчин төгөлдөр үйлчилнэ.
5. Сахилгын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвэл МХБХ-ны Сахилгын дүрмийн 88, 89 дүгээр зүйлд тус тус заасныг үндэслэн давж заалдах эрхтэйг дурдсугай.

ДАРГА

Ц.БАТСҮХ

